



СОЁМБО

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

МЭДЭЭ

№206 /416/

2022.11.15

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

Цаг үе, үйл явдал

АРТИЛЛЕРИЙН ЦЭРЭГ ҮҮСЭЖ ХӨГЖСӨНИЙ 101 ЖИЛИЙН ОЙД

МӨНХИЙН ГАВЬЯАТ МОНГОЛ ИХ БУУЧИД



Дэлхийн түүхэнд хүндтэй ул мөрөө үлдээж, цэргийн урлаг, тактикийн хөгжил дэвшилд гарамгай гавьяа байгуулж, олон удаагийн дайн тулалдаанд ялалтаа дархлан цуурайтуулсан Их Монгол Улсын эзэн хаан Чингисийн үеэс шашдир түүхээ эхэлж, эдүгээ Монгол Улсын туурга тусгаар аугаа их сэргэн мандалтын 20-р зуунд улс орныхоо хөгжил дэвшил, батлан хамгаалах ариун үйлсэд түүхэн гавьяатай, дайчин уламжлалт монгол их буучдын их үйлс үеийн үед дуурьсагдах болно.

Богд хаант Монгол Улсын үед Таван замын байлдааны олон удаагийн тулалдаанд баатарлаг гавьяа байгуулж байсан улаан залаат их буучид, Ардын хувьсгалын анхны их бууны галыг Монгол нутагт нээж, Ардын журамт цэргийг анхны ялалтад уриалан дуудсан Рэнцэн даргатай анхны их бууны салаа, 1921 оны 11 дүгээр сарын 15-нд жанжин Д.Сүхбаатарын санаачилгаар байгуулагдсан Өлзий даргатай анхны их бууны хороо, Ардын хувьсгалын партизан, анхны их буучдын нэг хошууч генерал Д.Цолмон, Ардын Армийн анхны их бууны командлагч, дивиз командлан захирагч Г.Жанцанжорлоо зэрэг Монголын их бууны цэргийн анхдагч дарга нарын гавьяат үйлс их бууны хөгжлийн түүхэнд алтан үсгээр бичигдэж, хойч үедээ үлдэх учиртай.

Монгол Улсын тусгаар тогтнол, улс орны батлан хамгаалах үйлсэд баатарлаг гавьяа байгуулж, ялалт байгуулсан домогт их буучид болох Монгол Улсын баатар хурандаа генерал Б.Цог, дэслэгч В.Шарав, байлдагч Л.Гэлэгбаатар Д.Данзанванчиг болон

дайны үед Ардын Армийн Жанжин штабын орлогч даргаар ажиллаж байсан алдарт их буучин хошууч генерал Г.Эрэндоо нарын манай их буучид дайн тулалдаанд баатарлаг зоригийн үлгэр дуурайлыг бусдад үзүүлж, мэргэжлийнхээ ур чадварыг өндөр хэмжээнд эзэмшсэний дээд илрэл болж байсныг өнгөрсөн түүх гэрчилнэ.

Их бууны цэргийн энх цагийн хөгжлийн түүхэн замналын эрин үед их бууны шинжлэх ухааныг Монгол орны өвөрмөц нөхцөлд бүтээлчээр хөгжүүлэх, их бууны цэргийн нэгтгэл, анги, салбаруудыг бүтэц, зохион байгуулалтын хувьд шинэчлэн байгуулж, тэднийг орчин цагийн дайн байлдаанд хэрэглэх арга ухаанд сурган дадлагажуулах, мэргэжлийн их буучдыг олноор бэлтгэх, их буучдын гал цохилтын ур чадварыг өндөр түвшинд хүргэж ялалтад бодит нөлөө үзүүлдэг, өнгөрсөн дайн, байлдааны туршлага, сургамжийг харгалзан их бууны цэргийн сургалт бэлтгэлийг шинэ шатанд гарган их бууны цэргийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан энх цагийн алдар хүндтэй их буучдын гавьяа, зүтгэл их билээ.

Ардын Армийн Жанжин штабын дарга асан, анхны мэргэжлийн их буучдын нэг дэслэгч генерал Ч.Пүрэвдорж, Армийн их бууны газрын даргыг 20-оод жил удирдсан алдарт их буучин хурандаа А.Шуувай, ахмад их буучин хурандаа Ж.Ваанчиг, Б.Шарав, доктор хурандаа Б.Товд, Цэргийн нэгдсэн дээд сургуулийн захирал асан хошууч генерал Г.Түмээ, БХЯ-ны 1 орлогч сайд болон 5 дугаар Армийн командлагч асан хошууч генерал

Д.Гэндэнпил, Улсын төлөвлөгөөний комиссын орлогч дарга, Их бууны газрын дарга болон ААБр-ын захирагч асан алдарт их буучин хурандаа Ж.Хүрэлжанцан, ЗХЖШ-ын орлогч дарга болон 6 дугаар МБД-ийн захирагч асан хошууч генерал Ч.Цэрэндагва, Армийн их бууны командлагч асан ахмад их буучин хурандаа Б.Арслан, Цэргийн их сургуулийн захирал болон Их бууны газрын дарга асан доктор хурандаа Я.Мягмарсүрэн, хурандаа Д.Янжингомбо, олон жил их бууны анги удирдаж байсан ахмад их буучин хурандаа Ч.Дондов, ААБр-ын захирагч асан хурандаа Н.Доржханд, их бууны дөрвөн анги удирдаж байсан ахмад их буучин хурандаа Ш.Нэргүй, хурандаа Б.Цагаан, ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба, их бууны шинжлэх ухааныг Монголд хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан, орчин цагийн их буучдыг бэлтгэн сургахад өөрийн мэдлэг чадвараа эгнэгт зориулсан Монголын анхны Их бууны эрдэмтэн, доктор, профессор хурандаа Д.Цэен, их бууны шинжлэх ухааны доктор Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн хошууч генерал О.Үржин, их бууны мэргэжлийн эрдэмтэд болох Д.Лхагвасүрэн, Н.Түүхбаатар, П.Алгаа, Я.Мягмарсүрэн, И.Батсайхан, Д.Содномцог, Б.Мандахбаяр, Чингисийн цэргийн урлаг, байлдах арга сэдвээр докторын зэрэг хамгаалсан анхны монгол түүхч эрдэмтэн их буучин хурандаа Х.Шагдар, ЗХЖШ-ын орлогч даргаар ажиллаж байсан хошууч генерал А.Ганбат, хошууч генерал Ж.Бадамбазар, Б.Баярмагнай, бригадын генерал Н.Энхбаялаг, Ц.Гандорж, ХЗЦК-ын штабын дарга асан их буучин хурандаа Ж.Уранбилэг, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Цэргийн их сургуулийн захирлаар ажиллаж байсан доктор, профессор, хошууч генерал З.Болдбаатар зэрэг орчин цагийн Монголын их бууны 100 жилийн түүхийг бичилцсэн алдарт их буучдыг нэрлэж болно.

Монголын их буучид эх орноо батлан хамгаалах их үйлсэд хүндтэй гавьяа байгуулахын зэрэгцээ орчин үед олон улсын энхийг сахиулах ажиллагаанд оролцож, тив дэлхийн аюулгүй байдлын манаанд идэвхтэй оролцоор байгаа нь бахархуштай билээ. ИБНАУ-ын их буучдыг сургаж бэлтгэх их үйлсэд мэргэжлийн туслалцаа үзүүлж, их буучдынхаа нэрийг дэлхийн тавцанд цуурайтуулсан нь монголчууд дэлхийд анх удаа их буг бүтээж, дайн тулалдаанд ашиглаж ялалт байгуулж, дэлхий дахиныг донсолгож, байлдан дагуулж байсан өвөг дээдсийнхээ түүхэн баатарлаг замналыг бахдан биширч, өнөөгийн Монголын их буучид домогт түүх шаштираараа бахархан омогшдогийг харуулсан билээ.

ЧИХРИЙН ШИЖИН-ЧИМЭЭГҮЙ ТАХАЛ



Чихрийн шижин өвчинтэй тэмцэх дэлхийн өдрийг тохиолдуулан Цэргийн төв эмнэлгээс “Чихрийн шижингийн нүдний халдвараас сэргийлье” сэдэвт өдөрлөгийг зохион байгууллаа.

Дэлхийн чихрийн шижингийн холбооноос гаргасан судалгаагаар дэлхийд чихрийн шижин буюу сахарын өвчлөлтэй 400 гаруй сая хүн байгаа бөгөөд тус статистик тоо 2030 он гэхэд 600 саяд хүрэх магадлалтай байгаа юм. Цэргийн төв эмнэлэг 2018 оноос хойш уг өвчинтэй тэмцэх,

өвчлөлийг бууруулах зорилгоор уг өдөрлөгийн арга хэмжээг тасралтгүй зохион байгуулсаар ирсэн бөгөөд энэ удаагийн өдөрлөгт 200 гаруй хүн хүрэлцэн иржээ.

ЦТЭ-гийн Дотоод шүүрэл булчирхайн нарийн мэргэжлийн эмч, дэслэгч Ч.НАРАНГЭРЭЛ: “Өнөө үед 10 хүн тутмын нэг нь сахартай, хоёр хүн тутмын нэг нь чихрийн шижингийн өвчлөлтэй гэдгээ мэдэхгүй явж байна. Тиймээс дэлхийн чихрийн шижингийн холбооноос энэхүү “чимээгүй тахал” гэгдэж буй өвчинтэй тэмцэх зорилгоор

жил болгоны 11 дүгээр сарын 14-ний өдрийг “Чихрийн шижинтэй тэмцэх өдөр болгон зарласан байдаг. Өдгөө чихрийн шижингийн өвчлөлтэй хөдөлмөрийн насны гурван хүн тутмын нэг нь хараа алдагдалтай гэсэн судалгаа гарсан учраас тус өдөрлөгийг “Чихрийн шижингийн нүдний хүндрэлээс сэргийлье” сэдвийн хүрээнд зохион байгуулж байна” гэлээ.

Өдөрлөгийн хүрээнд ЦТЭ-ээс ард иргэдэд чихрийн шижингийн үнэ төлбөргүй оношилгоог хийж сургалтад хамруулахын зэрэгцээ нэгэнт уг өвчнөөр өвчилсөн тохиолдолд

хэрхэн зөв зохистой хооллож, дасгал хөдөлгөөн хийх талаар зөвлөгөө мэдээлэл хүргэсэн юм. Мөн энэ удаагийн өдөрлөгт цэргийн нэгтгэл, анги, салбаруудын эмч нар уригдан оролцож байгаагаараа онцлог болж байгаа аж.

Иргэд тус өвчнөөр өвчилж буй шалтгаан нь тодорхой болон тодорхой бус гэсэн хоёр хэв шинжтэй. Тодорхой шалтгаан нь хөдөлгөөний хомсдол, таргалалт амьдралын болон хоолны буруу хэв маяг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагддаггүй байдалтай холбоотой гэдгийг холбогдох албаны хүмүүс хэлж байсан юм.



ЦАГ АГААР

| УЛААНБААТАР | |
|-------------|------|
| ӨДӨР | ШӨНӨ |
| 4 | -8 |

| ӨМНӨД СУДАН | |
|-------------|------|
| ӨДӨР | ШӨНӨ |
| 38 | 23 |

ВАЛЮТЫН ХАНШ

| ВАЛЮТ | АВАХ | ЗАРАХ |
|-------|-------|-------|
| USD | 3,435 | 3,445 |
| EUR | 3,520 | 3,550 |
| CNY | 480 | 482 |
| RUB | 53.70 | 54 |
| JPY | 24.30 | 24.60 |
| KRW | 2.61 | 2.64 |

ЗУРХАЙ



2022.11.15 /МЯГМАР ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 22

НАМРЫН АДАГ ЦАГААН НОХОЙ САР НАЙМАН ЦАГААН ЭНГЭТЭЙ ХАР БИЧ ӨДӨР

Үс засуулбал:
Идээ ундаа элбэг олдono
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
07.58-17.16
БАРИЛДЛАГА:
Үхэх
ШҮТЭН БАРИЛДЛАГА:
Нэр өнгө

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Эл өдөр амь таслах, хор найруулах үйлнээ зэрэгчлэн бүтнэ, үйл буруутгах, ламд золгох зэрэг цагаан зүгийн үйлэнд сайн. Баруун нүд татвал холын сураг сонсох, зүүн нь татвал эд олдох, баруун чих хангинавал ундаа олдох, зүүн чих хангинавал түлэгдэх, нохой уливал үхсэний сураг сонсох, хэрээ дуугарвал нөхөртэй учрах, тагнай загатнавал хувцас олдох, бие татвал эцэг, эхэд муу. Хөл татвал хэрүүл, тэмцэл гарах муу ёр болой.



| КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД | |
|---------------------------|-------------------|
| Тохиолдол | Нийт: 640,601,913 |
| Эдгэрсэн | Нийт: 620,317,629 |
| Нас барсан | Нийт: 6,616,337 |

